



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/407/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал Утас: 7007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn</p>
<p>ОБЖ/ОБЖ:</p>	<p>ОБЖ/ОБЖ:</p>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-11
3. Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5. Аудитын илрүүлэлт.....	12
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 382
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г.ГАНСЭЛЭМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу нийслэлийн Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийслэлийн ГХУСАЗСЗ-өөс 294.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, бүрэн зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дүүргийн хөрөнгө оруулалтаар 107.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, бүртгэж тайлагнасан байна.

1426050647

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргэ 2026\2026\word\word\сан бичиг\Dugnet_2026.docx

Бусад асуудал

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		<u>33,341,371.00</u>	<u>159,074,891.04</u>
33	АВЛАГА		-	2,874,475.04
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		-	2,874,475.04
34	УРЬДЧИЛГАА	5.0	-	113,815,339.00
34600	Урьдчилж гарсан зардал		-	113,815,339.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6.0	33,341,371.00	42,385,077.00
354	Хангамжийн материал		33,341,371.00	42,385,077.00
35410	Бичиг хэргийн материал		6,037,000.00	8,795,700.00
35440	Түлш, шатах тослох материал		150,000.00	1,200,000.00
35470	Бусад хангамжийн материал		27,154,371.00	32,389,377.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		<u>94,796,677.88</u>	<u>174,566,614.29</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7.0	94,796,677.88	174,566,614.29
392	Биет хөрөнгө		77,956,837.92	158,341,734.37
39201	Барилга, байгууламж, орон сууц		9,375,394.00	9,375,394.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		(2,812,618.08)	(3,281,387.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		32,130,000.00	32,130,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(32,130,000.00)	(32,130,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		141,167,511.00	230,829,850.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(92,688,982.05)	(97,163,453.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		56,808,783.00	52,375,595.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(38,643,249.75)	(37,594,262.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө		9,500,000.00	9,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(4,750,000.20)	(5,700,000.24)
393	Биет бус хөрөнгө		16,839,839.96	16,224,879.92
39301	Програм хангамж		22,924,800.00	28,324,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(6,604,960.04)	(12,619,920.08)
39303	Бусад биет бус хөрөнгө		520,000.00	520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		<u>128,138,048.88</u>	<u>333,641,505.33</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		<u>128,138,048.88</u>	<u>333,641,505.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		128,138,048.88	333,641,505.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		35,793,053.00	35,793,053.00
51101	Өмч: - төрийн		35,793,053.00	35,793,053.00
512	Хуримтлагдсан үр дүн		82,898,580.11	288,402,036.56
51210	Өмнөх үеийн үр дүн		82,898,580.11	82,898,580.11
51220	Тайлант үеийн үр дүн		-	205,503,456.45

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		9,446,415.77	9,446,415.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		128,138,048.88	333,641,505.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/				
Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2.0	1,459,602,752.59	1,382,009,797.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		-	107,234,557.00
120	Нийтлэг татварын бус орлого		-	107,234,557.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө			107,234,557.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,459,602,752.59	1,274,775,240.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		405,800,000.00	294,120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		405,800,000.00	294,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		1,053,802,752.59	980,655,240.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		1,053,802,752.59	980,655,240.71
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3.0	1,466,108,503.64	1,176,506,341.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,466,108,503.64	1,176,506,341.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,195,801,242.54	1,149,518,341.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		555,581,207.70	647,342,956.21
210101	Үндсэн цалин		274,384,007.22	302,841,273.72
210102	Нэмэгдэл		131,842,541.65	161,364,070.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		98,789,404.85	131,636,035.23
210104	Урамшуулал		50,565,253.98	51,501,577.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		70,171,584.03	80,859,751.53
210201	Тэтгэврийн даатгал		47,966,732.58	55,123,721.79
210202	Тэтгэмжийн даатгал		5,644,085.89	6,407,867.09
210203	ҮОМШӨ-ний даатгал		2,785,743.38	3,174,233.56
210204	Ажилгүйдлийн даатгал		2,755,004.65	3,174,233.56
210205	Эрүүл мэндийн даатгал		11,020,017.53	12,979,695.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		102,477.40	109,171.43
210302	Түлш, халаалт		102,477.40	109,171.43
2104	Хангамж, бараа материалын зардал		40,985,941.36	53,331,259.00

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210401	Бичиг хэрэг		3,419,330.00	3,153,480.00
210402	Тээвэр, шатахуун		11,219,300.00	7,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,308,701.36	3,771,915.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		24,038,610.00	34,265,870.00
210408	Бараа материал акалсны зардал		-	4,389,994.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,349,000.00	-
210604	Урсгал засвар		4,349,000.00	-
2107	Томилолт, зочны зардал		100,384,000.00	112,000.00
210701	Гадаад албан томилолт		99,400,000.00	-
210702	Дотоод албан томилолт		984,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		324,586,641.00	258,948,582.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		323,954,113.00	258,333,598.50
210803	Даатгалын үйлчилгээ		476,920.00	416,224.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		154,048.00	197,200.00
210807	Газрын төлбөр		1,560.00	1,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		99,640,391.05	108,814,620.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		71,249,000.00	75,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		28,391,391.05	33,814,620.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		270,307,261.10	26,988,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		270,307,261.10	26,988,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		203,000,000.00	3,750,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		39,134,295.10	16,788,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		28,172,966.00	6,450,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		(6,505,751.05)	205,503,456.45
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		(6,505,751.05)	205,503,456.45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,459,602,752.59	1,274,775,240.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,459,602,752.59	1,274,775,240.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	405,800,000.00	294,120,000.00

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	405,800,000.00	294,120,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,053,802,752.59	980,655,240.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,053,802,752.59	980,655,240.71
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,438,017,752.59	1,268,425,240.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,017,752.59	1,268,425,240.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,167,710,491.49	1,240,687,240.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	555,581,207.70	650,217,431.25
210101	Үндсэн цалин	274,384,007.22	305,715,748.76
210102	Нэмэгдэл	131,842,541.65	161,364,070.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	98,789,404.85	131,636,035.23
210104	Урамшуулал	50,565,253.98	51,501,577.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,171,584.03	80,859,751.53
210201	Тэтгэврийн даатгал	47,974,732.58	55,123,721.79
210202	Тэтгэмжийн даатгал	5,644,085.89	6,407,867.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,781,743.38	3,174,233.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,751,004.65	3,174,233.56
210205	Эрүүл мэндийн даатгал	11,020,017.53	12,979,695.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,477.40	109,171.43
210302	Түлш, халаалт	102,477.40	109,171.43
2104	Хангамж, бараа материалын зардал	41,286,581.36	61,265,595.00
210401	Бичиг хэрэг	2,788,630.00	3,341,880.00
210402	Тээвэр, шатахуун	9,999,300.00	8,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,308,701.36	3,771,915.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,189,950.00	45,351,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,349,000.00	113,815,339.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	113,815,339.00
210604	Урсгал засвар	4,349,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	100,384,000.00	112,000.00
210701	Гадаад албан томилолт	99,400,000.00	-
210702	Дотоод албан томилолт	984,000.00	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	324,586,641.00	259,307,952.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	323,954,113.00	258,692,968.50

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	476,920.00	416,224.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	154,048.00	197,200.00
210807	Газрын төлбөр	1,560.00	1,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,249,000.00	75,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,249,000.00	75,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	270,307,261.10	27,738,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	270,307,261.10	27,738,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	203,000,000.00	4,500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	39,134,295.10	16,788,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,172,966.00	6,450,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,585,000.00	6,350,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,585,000.00	6,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,585,000.00	6,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,585,000.00	6,350,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,585,000.00	6,350,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,585,000.00)	(6,350,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,793,053.00	9,446,415.77	89,404,331.16	134,643,799.93
Тайлант үеийн үр дүн	-	-	(6,505,751.05)	(6,505,751.05)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,793,053.00	9,446,415.77	82,898,580.11	128,138,048.88
Тайлант үеийн үр дүн	-	-	205,503,456.45	205,503,456.45
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,793,053.00	9,446,415.77	288,402,036.56	333,641,505.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/ Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,026,037,500.10	980,655,240.71	45,382,259.39	95.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,037,500.10	980,655,240.71	45,382,259.39	95.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	993,749,500.10	952,917,240.71	40,832,259.39	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,273,900.00	650,217,431.25	26,056,468.75	96.1
210101	Үндсэн цалин	303,922,000.00	305,715,748.76	(1,793,748.76)	100.6
210102	Нэмэгдэл	159,135,200.00	161,364,070.18	(2,228,870.18)	101.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,287,200.00	131,636,035.23	3,651,164.77	97.3
210104	Урамшуулал	77,929,500.00	51,501,577.08	26,427,922.92	66.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,456,000.00	80,859,751.53	4,596,248.47	94.6
210201	Тэтгэврийн даатгал	58,065,300.00	55,123,721.79	2,941,578.21	94.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,821,500.00	6,407,867.09	413,632.91	93.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,381,100.00	3,174,233.56	206,866.44	93.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,381,100.00	3,174,233.56	206,866.44	93.9
210205	Эрүүл мэндийн даатгал	13,807,000.00	12,979,695.53	827,304.47	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,000.00	109,171.43	65,828.57	62.4
210302	Түлш, халаалт	175,000.00	109,171.43	65,828.57	62.4
2104	Хангамж, бараа материалын зардал	47,936,100.10	41,265,595.00	6,670,505.10	86.1
210401	Бичиг хэрэг	3,800,000.00	3,341,880.00	458,120.00	87.9
210402	Тээвэр, шатахуун	9,999,900.10	8,800,000.00	1,199,900.10	88.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	3,771,915.00	228,085.00	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,136,200.00	25,351,800.00	4,784,400.00	84.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	950,000.00	950,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	950,000.00	950,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	112,000.00	138,000.00	44.8
210702	Дотоод албан томилолт	250,000.00	112,000.00	138,000.00	44.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,708,500.00	104,403,291.50	3,305,208.50	96.9

Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,000,000.00	98,388,307.50	8,611,692.50	92.0
210803	Даатгалын үйлчилгээ	477,900.00	416,224.00	61,676.00	87.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,200.00	197,200.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	5,400,000.00	(5,400,000.00)	-
210807	Газрын төлбөр	11,400.00	1,560.00	9,840.00	13.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,000,000.00	75,000,000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,000,000.00	75,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,288,000.00	27,738,000.00	4,550,000.00	85.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,288,000.00	27,738,000.00	4,550,000.00	85.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,500,000.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,788,000.00	16,788,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,000,000.00	6,450,000.00	4,550,000.00	58.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,026,037,500.10	980,655,240.71	45,382,259.39	95.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,026,037,500.10	980,655,240.71	45,382,259.39	95.6
132001	Орон нутгийн төсвөөс	1,026,037,500.10	980,655,240.71	45,382,259.39	95.6
1	Байгууллагын тоо	1.00	1.00	-	100.0
2	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
3	Ажиллагсадын тоо	16.00	16.00	-	100.0
4	Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.0
5	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.0
6	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0
24	Орон тооны мэдээлэл	16.00	16.00	-	100.0
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00	-	100.0
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	-	100.0
35	Улс төрийн албан хаагч (УТ)	4.00	4.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	294,120,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,120,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,815,339.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	113,815,339.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,304,661.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,304,661.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	294,120,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	294,120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	294,120,000.00

3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны чиг үүргийг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.1-д “*тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг, нутгийн өөрөө удирдах байгууллага мөн*” гэж тодорхойлсон.

Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь үйл ажиллагааны зорилгоо “*Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж үйл ажиллагаагаа сайжруулах, хурлын Төлөөлөгчид, ажлын албаны албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах, дэмжлэг тусалцаа үзүүлэх*” гэж тодорхойлон дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хууль дүрэм журмын дагуу байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах;
- Төлөөлөгчийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, төлөөлөгчдөд дэмжлэг үзүүлэх.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтад нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэж байна гэж дүгнэлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 763,837.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 763,837.2 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нийт 12,191.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 12,191.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 12,191.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гооцоолсон цалин хөлс, нэмэгдэл цалин, суутгалын дүнг анхан шатны баримт, ерөнхий журнал, санхүүгийн тайлантай тулгахад дансны бичилт цалингийн хүснэгтээс 763,837.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	763,837.2			1	763,837.2	1	763,837.2				
Дүн	1	763,837.2			1	763,837.2	1	763,837.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ГХУСАХЗ- аас "Хамтдаа шийдье"сэдэвт нээлттэй өдөрлөг, уулзалт зөвлөгөөнийг агаарт баазад зохион байгуулж, нийт 7,776.0 мянган төгрөгийн хоолны зардал гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	7,776.0					1	7,776.0				
"Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврын хэрэгжилтийг хангаагүй 1,540.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авсан байна.	1	1,540.6					1	1,540.6				
Төсвийг зөв зохистой удирдаагүй, цалингаас суутган тооцсон татварыг 2,874.5 мянган төгрөгөөр илүү төлж, авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна.	1	2,874.5					1	2,874.5				
Дүн	3	12,191.1					3	12,191.1	-	-	-	-

